

Төвийн цахим мэдээллийг дараах байдлаар ангилна.Үүнд:

№	Кибер мэдээллийн ангилал	Хамаарах мэдээллүүд
1.	Нээлттэй мэдээлэл	- Тусламж үйлчилгээний талаарх лавлагаа мэдээллүүд; - Үйлчлүүлэгчдэд зориулсан утас, цахим хаяг, хаяг байршлууд зэрэг холбоо барих мэдээлэл; - Эмч, ажилтнуудын овог нэр, зэрэг, дэв, цол, мэргэшсэн байдал зэрэг ерөнхий танилцуулга; - Тасаг, алба нэгжүүдийн танилцуулга, үйлчилгээний талаарх мэдээлэл; - Үзлэг, үйлчилгээний журам, захирлын холбогдох тушаалууд болон удирдлагын шийдвэр; - Цагийн хуваарь, цаг авах үйлчилгээтэй холбоотой мэдээлэл; - Цахим хуудсанд олон нийтэд зориулж байршуулсан мэдээллүүд; - Эрүүл мэндийн зөвлөгөө, сургалт, сурталчилгаа, уриалга, сэрэмжлүүлэг; - Байгууллагын төлөвлөгөө, тайлан; - Сэтгэл ханамжийн судалгааны үр дүн; - Төсөв, санхүү, худалдан авах үйл ажиллагааны талаарх мэдээлэл; - Эмнэлгийн тусламж үйлчилгээний үндсэн үзүүлэлт; - Төсөл хөтөлбөрийн төлөвлөгөө, тайлан; - Бусад төрлийн байгууллагын ил тод байдлыг илэрхийлсэн мэдээ, мэдээллүүд;
2.	Хязгаарлагдмал мэдээлэл	- Байгууллагын ажилтнуудад зориулсан мэдээ, мэдээлэл; - Удирдлагаас батлан гаргасан аливаа шийдвэр, захирлын тушаал; - Үүрэг даалгавар, түүний гүйцэтгэл; - Эмч, ажилтнуудын хувийн хэрэг зэрэг хүний нөөцийн мэдээллийн сан; - Алдаа, эрсдэлийн сан; - Хувь хүнд өөрт нь болон ар гэрийнхэнд нь зориулсан оношилгоо, шинжилгээний хариу, биеийн байдал; - Үзлэг, оношилгоо, шинжилгээний явцын тухай мэдээлэл; - Төвийн үйл ажиллагааны үндсэн болон бусад үзүүлэлтүүд; - Өдөр тутмын үйл ажиллагааны мэдээллүүд; - Гэрээ, хэлцлүүд; - Эрх бүхий ажилтны зөвшөөрөлтэй авч болох бусад төрлийн мэдээ, мэдээлэл, сан гэх мэт
3.	Нууц мэдээлэл (шаардлагатай гэж үзвэл онц нууц, маш нууц, нууц гэсэн зэрэглэл тогтоож болно.)	- Мэдээллийн систем, программ хангамж болон тоног төхөөрөмжүүдэд хандах, нэвтрэх эрх; - Мэдээллийн серверт нэвтрэх эрх; - Өгөгдлийн санд хандах, нэвтрэх эрх, кодчиллол; - Байгууллагын сүлжээний бүтэц, мэдээллийн технологийн дэд бүтцийг харуулсан аливаа зураг, зураглал, кодчиллол, холбогдох мэдээлэл; - Мэдээллийн технологийн тоног төхөөрөмжүүдийн тохиргоо, тэдгээрт хандах эрх, хамгаалалтын түвшний талаарх мэдээлэл; - Байгууллагад бүртгэлтэй хүн амын сан; - Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн мэдээлэл агуулсан өвчний түүхийн, амбулаторийн үзлэгийн гэх мэт өгөгдөл, мэдээллийн сангууд; - Байгууллагын нууцад хамаарах бусад мэдээ, мэдээллүүд, өгөгдлийн сан гэх мэт



- 5.1 Төвийн цахим мэдээллийг зэрэглэлээр нь ангилан ялгаж тэмдэглэхдээ Эрүүл мэндийн сайдын холбогдох тушаалын заалтыг дагаж мөрдөнө
- 5.2 Төвийн кибер аюулгүй байдалтай уялдуулан байгууллагын орчин, өрөө тасалгааг дараах байдлаар бүсчилж ангилна.Үүнд:

№	Цахим мэдээлэл байрлах орчны ангилал	Хамаарах орчин	Хариуцагч
1.	Нээлттэй бүс	- Цахим бүртгэл - Хүлээлгийн танхим - Уулзалтын өрөө - Зөвлөгөө өгөх өрөө - Нийтийн коридор	- Хариуцсан тасаг нэгжийн удирдлага, нийт ажилтнууд
2.	Нийтэд хаалттай бүс	- Сахиурын өрөө - Эмч, ажилтнуудын өрөө - Үзлэг, шинжилгээ, тарианы өрөө - Тусгаарлах өрөө - Өвчтөний өрөө гэх мэт эмчилгээ үйлчилгээний зориулалтын өрөө тасалгаа - Хурал уулзалтын өрөө	- Хариуцсан тасаг нэгжийн удирдлага - Тухайн өрөөг хариуцсан ажилтан
3.	Хаалттай бүс	- Мэдээллийн серверийн өрөө - Сүлжээний зангилаа свич байршсан өрөө, тасалгаа - Өрөөнүүд доторх зангилаа төхөөрөмж байрласан хэсэг - Агуулах, архив зэрэг - Дээвэр	- Мэдээллийн технологийн алба - Тухайн өрөөг хариуцсан ажилтан - Нярав болон бусад хариуцсан ажилтан - Хариуцсан тасаг нэгжийн удирдлага